



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/141

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1./а/, 29.2, Ахмад настны тухай хуулийн 13.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ач санах” дэд хөтөлбөрийн хүрээнд ахмад зохиолчдыг дэмжих зорилгоор Б.Нямсүрэнд “Гэрэлт шагай” номыг хэвлүүлэхэд 800 000 төгрөгийн, Д.Дамдинсүрэнд “Цаг тоолол, зурхайн насан туршийн хэрэгцээнд” номыг хэвлүүлэхэд 500 000 төгрөгийн, М.Толяд “Улс төрийн шинжлэх ухааны үндэс” номыг хэвлүүлэхэд 1 000 000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2 300 000 /Хоёр сая гурван зуун мянган/ төгрөгийг “Ач санах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ